



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 22 -ны өдөр

Дугаар А/41

Эрдэнэт

“Журам батлах тухай”

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 31дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/248 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь :


1. Халдварын голомтот бүс нутгаас ирсэн, батлагдсан тохиолдлын ойрын болон дам хавьтал, коронавируст халдвар /ковид-19/-ын тусгаарлан ажиглах байрнаас гарсан, эмчлэгдэн эдгэрсэн иргэдийг гэрийн ажиглалтад байх хугацаанд хянах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, тандалт судалгаанд хамруулах журмыг нэгдүгээр, хүн амын дунд коронавируст халдварын шинж тэмдгийн тандалт судалгааны асуумжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гэрийн ажиглалтын хяналт болон хүн амын дунд коронавируст халдварын шинж тэмдгийн тандалт судалгааг тогтмол, хариуцлагатай зохион байгуулж эргэн мэдээлж ажиллахыг Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрийн тусгаарлалт, ажиглалтад тавих хяналт, тандалт судалгааны явцад өдөр бүр хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн / Б.Хишигжаргал/-д үүрэг болгосугай.

5. Тус тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тайлагнаж ажиллахыг хариу арга хэмжээний багийн ахлагч / А.Баярхүү/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

My doc. EMG-iin dargiin tushaal

Гэрийн ажиглалтад байх иргэдэд
тусламж үйлчилгээ үзүүлэх түр журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Халдварын голомтот бүс нутгаас ирсэн, батлагдсан тохиолдлын ойр болон дам хавьтал, коронавируст халдвар /ковид-19/-ын тусгаарлан ажиглах байрнаас гарсан, эмчлэгдэн эдгэрсэн иргэдийг гэрийн ажиглалтад байх хугацаанд хянах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, тандалт судалгаанд халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, тандалт судалгаанд хамруулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Гэрийн ажиглалтын үйл ажиллагааг зохицуулахдаа хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх, хүнийг эрхийг хангах, шуурхай, ил тод байх, хувь хүний нууцыг чанд хадгалах зарчмыг баримтална.
- 1.3. Гэрийн ажиглах хугацааг Улсын онцгой комиссын даргын 2021 оны 31 дүгээр тушаалд зааснаар баримтална.

Хоёр. Эрүүл мэндийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- 2.1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг гэрийн тусгаарлалт, ажиглалтад хяналт хийхэд удирдлага, зохион байгуулалтаар хангах
- 2.2. Гэрийн ажиглалтад байгаа иргэдэд тавьж буй эрүүл мэндийн хяналт, үр дүнгийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бэрхшээлтэй, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх
- 2.3. Гэр ажиглалтад байгаа иргэдэд тавьж буй хяналтын үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулж буй иргэдийг холбогдох байгууллагад уламжлах
- 2.4. Шаардлагатай тохиолдолд сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу гэрийн ажиглалтад байгаа иргэнд төрөлжсөн мэргэшлийн эмчийн тусламж үйлчилгээг үзүүлэх, зөвлөгөө мэдээллийг шуурхай авах үйл ажиллагааг зохицуулах
- 2.5. Гэрийн ажиглалтад байгаа иргэний хяналтын болон эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээллийг нэгтгэж холбогдох байгууллагуудад хүргүүлэх

Гурав. Сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- 3.1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь өдөр бүр "ctr.erdenetmc.mn" программд нэвтрэх эрхийн дагуу хандаж ойр, дам хавьтал болон голомт бүхий бүс нутгаас ирсэн иргэдийн мэдээллийг авахаас гадна тусгаарлах байрнаас болон ковидын тасгаас эмчлэгдэн гэрийн ажиглалтад шилжиж буй иргэдийн мэдээллийг ЭМГ-ын холбогдох мэргэжилтнээс авч иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэх, тандалт судалгаанд хамруулах арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах
- 3.2. Багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, цагдаагийн хэсэгтэй хамтран гэрийн ажиглалтад байгаа иргэдэд хяналт тавих, шаардлагатай тусламж үйлчилгээний зохицуулалтыг хийж, ажиглалтад байх хугацаанд хөл хорионы дэглэмийг мөрдүүлэх
- 3.3. Эрүүл мэндийн талаар мэдээлэх хугацаа, халдвар хамгааллын дэглэм, ажиглалтад байх иргэн болон түүний гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг сануулан, утсаа байнга нээлттэй байлгах, гэрээс гарч болохгүй талаар байнга анхааруулах, Эрүүл мэндийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу тандалт, шинжилгээнд хамруулах

- 3.4. Гэрийн ажиглалтад буй иргэдэд өдөр бүр шинж тэмдгийн тандалт хийх ба "ctr.erdenetmc.mn" программ-д зааврын дагуу тэмдэглэгээ хийж үзүүлсэн тусламж үйлчилгээгээ баримтжуулах
- 3.5. Коронавируст халдвар (ковид-19)-ын халдварт өртөж эмчлүүлэн эмнэлгээс гарсан иргэний гэрийн ажиглалтад байх өдрүүдэд өдөр бүр утсаар холбогдон эмнэлзүйн шинж тэмдгээр хянаж шаардлагатай тохиолдолд халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлэх, 2 дахь шатны эрүүл мэндийн байгууллагаас зөвлөгөө авах
- 3.6. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь өөр хоорондоо ойр, дам хавьтлуудын мэдээллийг шуурхай солилцох, хавьтлыг илрүүлэх, тандах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах
- 3.7. Гэрийн ажиглалтад байх иргэдээс амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгчийг гэрт нь тусгаарлан ПГУ-ын шинжилгээнд яаралтай хамруулж тандах, тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх
- 3.8. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь цахим хуудсаараа дамжуулан иргэдэд коронавируст халдвараас сэргийлэх, халдварын үед илрэх шинж тэмдэг, ажлын болон ажлын бус цагаар холбоо барих утасны дугаар хаана, хэнд хандах тухай зөвлөмжийг байршуулж, иргэдийг мэдээллээр хангаж ажиллах
- 3.9. Голомт бүхий бүс нутгаас ирсэн иргэдээс гадна эрсдэлт бүлгийн хүн ам ялангуяа өндөр настан, архаг хууч өвчтэй, гэртээ ганцаараа болон цөөн ам бүлтэй ахмадуудын гэрийн хяналтыг сайжруулж, өдөр бүр утсаар холбогдон мэдээлэл авах, шаардлагатай тохиолдолд гэрт нь очиж тусламж, үйлчилгээ үзүүлэх
- 3.10. Коронавируст халдвар (ковид-19)-ын хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллах хугацаанд гэрийн дуудлагаар болон товллын дагуу гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зохицуулалтыг тухай бүр хийх
- 3.11. Амбулаториор үйлчлүүлсэн болон өөрийн харьяаллын хөдөлгөөнт хүн ам, эрсдэлт бүлгийн иргэдээс коронавируст халдвар /ковид-19/-ыг илрүүлэх шинж тэмдгийн тандалт судалгааг хийж, халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг тусгаарлан шинжилгээнд шуурхай хамруулж, хариу арга хэмжээг авах
- 3.12. Коронавируст халдвар /ковид-19/-ыг илрүүлэх шинж тэмдгийн тандалт судалгааны мэдээллийг 14 хоног тутамд цахимаар Эрүүл мэндийн газарт хугацаанд нь ирүүлж ажиллах

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 04 сарын 22-ны өдрийн
А/Н/ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Хүн амын дунд коронавируст халдвар /ковид-19/-ыг илрүүлэх шинж
тэмдгийн тандалт судалгааны асуумж

№	Илэрсэн эмнэлзүйн шинж тэмдгүүд	Тийм	Үгүй	Шинж тэмдэг илэрсэн он сар өдөр
1	Халуурах (>37.1°C)			
2	Хоолой хөндүүрлэх /өвдөх/			
3	Хуурай ханиалгах			
4	Нусгайрах			
5	Хамар битүүрэх			
6	Үнэрлэх мэдрэхүй алдагдах			
7	Амтлах мэдрэхүй алдагдах			
8	Амьсгал давчдах			
9	Жихүүдэс хүрэх			
10	Бөөлжих			
11	Дотор муухайрах			
12	Суулгах			
13	Толгой өвдөх			
14	Тууралт гарах			
15	Нүд үрэвсэх			
16	Булчингаар өвдөх			
17	Үе мөч өвдөх			
18	Хоолонд дургүй болох			
19	Хамраас цус гарах			
20	Ядрах, сульдах			
21	Татах			
22	Ухаан балартах			
23	Мэдрэлийн бусад шинж тэмдэг			
24	Бусад шинж тэмдэг			

Жич: Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь эхний тандалтын мэдээг 2021.04.23-нд ирүүлсэн байна.